



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад
бүртгэлтэй “Степ голд лимитед”-ийн үнэт цаасыг
нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт
цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.10, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын 3.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 256 дугаар тогтоолоор бүртгэсэн “Степ голд лимитед”-ийн нийт 69,533,717 /жаран есөн сая таван зуун гучин гурван мянга долоон зуун арван долоо/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/, төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д тус тус үүрэг болгосугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

